



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21
6	Төлбөрийн акт .....	23

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН Х.СОНИНБАЯР  
ТАНАА

2019.04.25 № 852  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон УСНББОУС, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг түр орлон гүйцэтгэгч, Иргэний хэргийн танхимын Тэргүүн Х.Сонинбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, авлага, өр төлбөргүй санхүүгийн тайлан бэлтгэх, авто тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс 4 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Болор-Эрдэнэ хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын Дээд шүүх 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 1/1365 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.



Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад, дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улсын Дээд шүүхийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол Улсын Дээд шүүх нь дараах эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох;
- Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг хамгаалах;
- Хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх;
- Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх.

Улсын Дээд шүүх төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын шүүхийн тухай хууль
- Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг





шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улсын Дээд шүүхийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийг хөгжүүлэх сан боловсруулан, 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдөр баталж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгааг судалж үзэхэд Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын Дээд шүүхийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын Дээд шүүх нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Интерактив Би Ай" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн "Emerald" програм хангамж ашигладаг байна.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Улсын Дээд шүүхийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг 1.0 хувиар сонгов.

Тус байгууллагын өмнөх оны аудитын дүгнэлтийг үндэслэн суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгох нь зүйтэй гэж үзсэн.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,004.3 сая төгрөгийн 1 хувь буюу 40.04 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн боловч санхүүгийн тайланд үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авч орлогоор тайлагнаснаар 46.4 сая төгрөгөөр өөрчлөгдсөнийг тодорхойлж, баталгаажууллаа.



Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Улсын Дээд шүүхэд төсвийн шууд болон төсвийн төвлөрүүлэн захирагч харьяа байгууллага харьяалагддаггүй тул аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлээ.

Аудитаар нийт 666.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 648.1 сая төгрөгийн залруулга, 1.9 сая төгрөгийн акт, 16.7 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Хүснэгт 1 (Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал, сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн
1	Зөвлөмж өгсөн	4	16.7
2	Төлбөрийн акт тогтоосон	2	1.9
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>18.6</b>

Эх сурвалж: Аудитын горим, сорилын ажлын баримт

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### Асуудал 1: Зардлын данстай холбоотой асуудал

Тайлант онд “Ард даатгал” ХХК-тай D181003109476 дугаар гэрээ байгуулж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийн амь нас, эрүүл мэндийг даатгуулахдаа томилогдоогүй нэг шүүгчийн даатгалын зардал 1.7 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдтэй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Шийдэл:** Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

#### Асуудал 2: Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Тамгын газрын даргын 2018 оны А/67 дугаар тушаалаар 14 албан хаагчид нийт 2.5 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл 0.3 сая төгрөгийг суутгалгүй илүү олгосон байна.





Энэ нь “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдтэй, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Шийдэл:** Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Улсын Дээд шүүх нь 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Хан-Уул дүүргийн нутагт орших Богдхан уулын дархан цаазат газрын хилийн зааг дотор Зайсангийн амны хязгаарлалтын бүсэд 0.6 га газрыг Сургалт мэдээллийн төвийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор ашиглах эрхийн гэрчилгээ авч 2011 онд тус төвийг барих зураг төсвийг 36.9 сая төгрөгөөр хийлгэж, Тусгай хамгаалалттай нутгийн захиргаатай 2013 оны 6 дугаар сарын 18-ны өдөр “Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээ” байгуулж, дээрх төлбөрийг урьдчилж төлсөн зардлаар тайлагнаж ирсэн бөгөөд хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүйн улмаас тус газрыг одоог хүртэл ашиглаж эхлээгүй байна.

Дээрх газрын төлбөрт тайлант онд 8.6 сая төгрөг төлсөн, цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улсын Дээд шүүхийн Сургалт мэдээллийн төвийг барих төсөв батлагдах эсэх нь тодорхойгүй байгаа асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улсын Дээд шүүх чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 2018 онд 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 3,998.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, тайлант хугацаанд 3,702.1 сая төгрөг зарцуулсан ба түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Улсын Дээд шүүх Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Дээрх хүлээсэн үүргийн дагуу 2018 онд нийт 183 мэдээлэл байршуулахаас санхүүжилт болон зарцуулалтын 175 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, иж бүрэн байршуулж, хугацаа хоцроосон 8 мэдээллээс шалтгаалан хэрэгжилт 95.6 хувьтай байна.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг аудитын явцад дахин нягталж үзэхэд 95.0 хувьтай бөгөөд дотоод аудитын үйл ажиллагаанд цаашид төсөв, санхүүгийн аудит хийх талаар анхаарч ажиллахыг зөвлөж ажиллав.

2017 оны зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.



### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдсан.



### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улсын Дээд шүүхийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой

##### 3.1.1 Илрүүлэлт:

Хэвлэл мэдээллийн 3 байгууллагад 2019 онд мэдээлэл, зар сурталчилгаа явуулах 7.1 сая төгрөгийг данс хаагдах өдөр шилжүүлж, авлагаар бүртгэсэн тул 2018 оны санхүүгийн тайланд авлагын данс өмнөх оны эцсийн үлдэгдлээс 6.3 сая төгрөгөөр өссөн байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Энэ нь “Иж бүрэн”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Авлага, өр төлбөрийг урьдчилан тооцоолж, тайлант хугацаанд барагдуулахад анхаарч ажиллах.

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага В20101, В501 маягтад заагдсан асуудлын бүртгэлтэй танилцан, хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

#### 3.2 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

##### 3.2.1 Илрүүлэлт:

Нийтийн эзэмшлийн бетондсон болон асфальтан 0.3 сая төгрөгийн талбай Чингэлтэй дүүргийн дансанд давхар бүртгэлтэй, 42.9 сая төгрөгийн дулааны ялтсан бойлер аргачлалд тусгагдаагүй тул дахин үнэлгээнд хамрагдаагүй байна.



### 3.2.2 Эрсдэл:

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Давхар бүртгэлтэй нийтийн эзэмшлийн зам талбайг данснаас хасах, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага В20101, В501 маягтад заагдсан асуудлын бүртгэлтэй танилцан, хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

## **3.3 Зардлын данстай холбоотой асуудал**

### 3.2.1 Илрүүлэлт:

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс санхүүгийн тайланд бүртгэлтэй 13 автомашинд нийт 10.1 сая төгрөгийн урсгал засвар хийхдээ техникийн комиссын гишүүдийн дүгнэлтийг тухай бүр гаргуулалгүй үйлчилгээ хийгдсэн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 заалт, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Автомашин аюулгүй байдлыг хангах Техникийн комиссын ажиллах журам баталж ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага В20101, В501 маягтад заагдсан асуудлын бүртгэлтэй танилцан, хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

## **3.4 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт**

### 3.2.1 Илрүүлэлт:

2018 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нийт 261.0 сая төгрөгөөр батлагдаж Тамгын газрын даргын 2018 оны А/03, А/14А, А/15А дугаар тушаалаар байгууллагын төсвийн зарцуулалтын хоёрдугаар гарын үсэг зурж буй Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн даргыг Үнэлгээний хорооны даргаар томилж ажиллуулсан нь санхүүгийн хяналт алдагдах эрсдэл учирч болохоор байна.

### 3.2.2 Эрсдэл:

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.



### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох эрх зүйн актуудад нийцүүлж ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага В20101, В501 маягтад заагдсан асуудлын бүртгэлтэй танилцан, хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын зүйл	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>275,703.9</b>	<b>366,219.1</b>
<b>АВЛАГА</b>	4,950.3	10,048.7
Бусад авлага	1,150.3	0.0
Байгууллагаас авах авлага	3,800.0	10,048.7
<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>36,965.6</b>	<b>36,965.6</b>
Урьдчилж гарсан зардал	36,965.6	36,965.6
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>233,787.9</b>	<b>319,204.8</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>233,787.9</b>	<b>319,204.8</b>
Бичиг хэргийн материал	61,647.6	67,870.3
Аж ахуйн материал	71,259.9	119,512.9
Сэлбэг хэрэгсэл	250.0	250.0
Түлш, шатах тослох материал	46,094.2	50,192.2
Хүнсний материал	1,180.3	1,872.5
Бусад хангамжийн материал	53,355.9	79,506.8
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>655,493.5</b>	<b>2,934,370.4</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>655,493.5</b>	<b>2,934,370.4</b>
Биет хөрөнгө	647,488.2	2,643,391.2
Барилга, байгууламж, орон сууц	637,038.9	2,343,919.3
Хуримтлагдсан элэгдэл	-407,057.3	-18,687.0
Авто-тээврийн хэрэгсэл	984,972.8	984,972.8
Хуримтлагдсан элэгдэл	-879,221.5	-962,557.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	532,693.3	569,961.8
Хуримтлагдсан элэгдэл	-341,308.7	-420,062.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	369,705.5	420,689.1
Хуримтлагдсан элэгдэл	-250,370.3	-275,762.0
Бусад үндсэн хөрөнгө	13,744.6	13,744.6
Хуримтлагдсан элэгдэл	-12,709.0	-12,827.7
Биет бус хөрөнгө	8,005.2	290,979.1
Програм хангамж	19,844.4	27,394.4
Хуримтлагдсан элэгдэл	-11,839.2	-16,320.4
Бусад биет бус хөрөнгө	0.0	279,905.1
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>931,197.3</b>	<b>3,300,589.4</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>931,197.3</b>	<b>3,300,589.4</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>931,197.3</b>	<b>3,300,589.4</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,148,315.0	1,428,220.1
Хуримтлагдсан үр дүн	-355,646.5	472,533.0
Өмнөх үеийн үр дүн	-252,958.1	-355,646.5
Тайлант үеийн үр дүн	-102,688.4	828,179.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	138,528.8	1,399,836.3
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>931,197.3</b>	<b>3,300,589.4</b>





#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,089,515.2</b>	<b>4,641,436.1</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,377.6</b>	<b>637,887.2</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,377.6</b>	<b>637,887.2</b>
Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,305.5	-
Бусад орлого	72.1	784.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	637,103.2
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,083,137.6</b>	<b>4,003,548.9</b>
<b>Татаас санхүүжилтийн орлого</b>	<b>4,083,137.6</b>	<b>3,998,145.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	4,083,137.6	3,998,145.9
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>5,403.0</b>
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,403.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,192,203.6</b>	<b>3,813,256.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,192,203.6</b>	<b>3,813,256.6</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,489,292.8</b>	<b>3,469,552.1</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,416,042.5</b>	<b>2,366,358.5</b>
Үндсэн цалин	2,416,042.5	2,362,947.3
Нэмэгдэл цалин	-	3,411.2
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>262,474.8</b>	<b>280,453.1</b>
Тэтгэврийн даатгал	214,352.1	194,923.0
Тэтгэмжийн даатгал	12,030.7	23,407.3
ҮОМШ өвчний даатгал	9,624.5	10,626.7
Ажилгүйдлийн даатгал	2,406.1	4,681.5
Эрүүл мэндийн даатгал	24,061.4	46,814.6
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,071.0</b>	<b>70,103.1</b>
Гэрэл цахилгаан	21,730.2	20,946.6
Түлш, халаалт	21,805.9	24,985.8
Цэвэр, бохир ус	3,611.9	3,210.7
Байрны түрээс	14,923.0	20,960.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>86,541.3</b>	<b>86,091.9</b>
Бичиг хэрэг	26,262.3	26,363.2
Тээвэр шатахуун	32,374.0	36,302.0
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	19,338.3	18,937.1
Ном, хэвлэл	7,686.0	4,140.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	880.7	349.0
<b>Нормативт зардал</b>	<b>240.0</b>	<b>79.8</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	240.0	79.8
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>90,644.7</b>	<b>25,791.5</b>
Урсгал засвар	90,644.7	25,791.5
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>83,424.6</b>	<b>131,362.0</b>
Дотоод албан томилолт	82,941.6	131,362.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	483.0	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>75,251.9</b>	<b>81,636.3</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,104.0	5,357.8



Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Даатгалын үйлчилгээ	45,330.9	49,080.4
Тээврийн хэрэгслийн татвар	1,780.7	1,097.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	321.4	319.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,099.5	16,281.2
Газрын төлбөр	8,615.4	9,500.3
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>412,602.1</b>	<b>427,676.1</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	60,237.8	39,204.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	139,486.4	164,592.6
Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	212,877.9	223,879.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>702,910.8</b>	<b>343,704.5</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,969.5</b>	<b>46,565.9</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,882.9	26,296.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,086.6	20,269.0
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>687,941.3</b>	<b>297,138.6</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	687,941.3	296,064.3
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх, шилжүүлэг	-	1,074.3
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>-102,688.4</b>	<b>828,179.5</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>-102,688.4</b>	<b>828,179.5</b>



#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,089,515.2</b>	<b>4,003,548.9</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,377.6</b>	<b>5,403.0</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,377.6</b>	<b>5,403.0</b>
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,305.5	5,403.0
Бусад орлого	72.1	-
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,083,137.6</b>	<b>3,998,145.9</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,083,137.6	3,998,145.9
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,083,137.6	3,998,145.9
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,031,910.6</b>	<b>3,900,425.4</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,031,910.6</b>	<b>3,900,425.4</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,307,945.9</b>	<b>3,557,091.9</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,375,005.1</b>	<b>2,335,608.3</b>
Үндсэн цалин	1,561,711.2	1,665,280.6
Нэмэгдэл	650,647.4	490,688.8
Унаа хоолны Хөнгөлөлт	162,646.5	159,625.4
Урамшуулал	-	20,013.5
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>284,619.1</b>	<b>310,904.4</b>
Тэтгэврийн даатгал	284,619.1	310,904.4
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,071.0</b>	<b>70,103.1</b>
Гэрэл, цахилгаан	21,730.2	20,946.6
Түлш, халаалт	21,805.9	24,985.8
Цэвэр, бохир ус	3,611.9	3,210.7
Байрны түрээс	14,923.0	20,960.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>141,253.0</b>	<b>146,078.6</b>
Бичиг хэрэг	30,745.3	39,683.4
Тээвэр, шатахуун	50,500.0	40,400.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,520.9	18,937.1
Ном, хэвлэл	13,988.5	4,183.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,498.3	42,874.5
<b>Нормативт зардал</b>	<b>1,629.7</b>	<b>4,656.9</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,629.7	4,656.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>131,548.1</b>	<b>285,247.9</b>
Багаж, техник, хэрэгсэл	1,279.9	4,358.5
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	490.1	2,656.5
Урсгал засвар	129,778.1	278,232.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>84,476.6</b>	<b>162,427.8</b>
Дотоод албан томилолт	82,941.6	161,571.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,535.0	856.8
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>84,948.8</b>	<b>96,114.7</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,262.4	17,266.0
Даатгалын үйлчилгээ	47,433.0	50,497.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,809.4	19,171.4



Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Газрын төлбөр	8,444.0	9,180.3
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>142,394.5</b>	<b>145,950.2</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	1,049.8	4,977.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	141,344.6	140,973.0
<b>ТАТААС</b>	<b>723,964.7</b>	<b>343,333.5</b>
Татаас шилжүүлэг	687,941.3	297,138.6
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,023.4</b>	<b>46,194.9</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,023.4</b>	<b>46,194.9</b>
Бусад мөнгөн зарлага	145.0	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,882.9	26,296.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,896.6	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,098.9	19,898.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>57,754.9</b>	<b>103,123.5</b>
Биет ба биет бус хөрөнгө оруулалтын зардал	57,754.9	103,123.5
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-57,754.9	-103,123.5
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-150.2</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>150.2</b>	<b>-</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>



#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	<i>/мянган төгрөгөөр/</i>
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,148,315.0</b>	<b>138,528.8</b>	<b>-252,958.1</b>	<b>1,033,885.7</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,148,315.0	138,528.8	-252,958.1	1,033,885.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-102,688.4	-102,688.4
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-	-
<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,148,315.0</b>	<b>138,528.8</b>	<b>-355,646.5</b>	<b>931,197.3</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,148,315.0	138,528.8	-355,646.5	931,197.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	1,345,074.4	-	1,624,979.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-83,766.9	-	-83,766.9
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	828,179.5	828,179.5
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	279,905.1	-	-	-
Үндсэн хөрөнгийн бууралт	-	-	-	-
<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,428,220.1</b>	<b>1,399,836.3</b>	<b>472,533.0</b>	<b>3,300,589.4</b>



#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,998,145.9</b>	<b>3,702,081.6</b>	<b>296,064.3</b>	<b>92.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,998,145.9</b>	<b>3,702,081.6</b>	<b>296,064.3</b>	<b>92.6</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,948,564.7</b>	<b>3,655,886.7</b>	<b>292,678.0</b>	<b>92.6</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,589,377.8</b>	<b>2,335,608.3</b>	<b>253,769.5</b>	<b>90.2</b>
Үндсэн цалин	1,794,612.9	1,665,280.6	129,332.3	92.8
Нэмэгдэл цалин	600,830.1	490,688.8	110,141.3	81.7
Унаа хоолны Хөнгөлөлт	159,625.4	159,625.4	-	100.0
Урамшуулал	34,309.4	20,013.5	14,295.9	58.3
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>310,904.4</b>	<b>310,904.4</b>	-	<b>100.0</b>
Тэтгэврийн даатгал	310,904.4	310,904.4	-	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,261.3</b>	<b>70,103.1</b>	<b>1,158.2</b>	<b>98.4</b>
Гэрэл, цахилгаан	21,456.6	20,946.6	510.0	97.6
Түлш, халаалт	25,010.3	24,985.8	24.5	99.9
Цэвэр, бохир ус	3,729.4	3,210.7	518.7	86.1
Байрны түрээс	21,065.0	20,960.0	105.0	99.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>153,156.4</b>	<b>141,749.9</b>	<b>11,406.5</b>	<b>92.6</b>
Бичиг хэрэг	43,563.8	35,354.7	8,209.1	81.2
Тээвэр, шатахуун	40,534.7	40,400.0	134.7	99.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,082.4	18,937.1	2,145.3	89.8
Ном, хэвлэл	5,090.3	4,183.6	906.7	82.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,885.2	42,874.5	10.7	99.9
<b>Нормативт зардал</b>	<b>4,656.9</b>	<b>4,656.9</b>	-	<b>100.0</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,656.9	4,656.9	-	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>376,674.6</b>	<b>376,470.6</b>	<b>204.0</b>	<b>99.9</b>
Багаж, техник, хэрэгсэл	67,075.0	67,075.0	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,656.5	2,656.5	-	100.0
Урсгал засвар	306,943.1	306,739.1	204.0	99.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>162,476.6</b>	<b>162,427.8</b>	<b>48.8</b>	<b>99.9</b>
Дотоод албан томилолт	161,619.8	161,571.0	48.8	99.9
Зочин төлөөлөгч хүлээн авах	856.8	856.8	-	100.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>133,714.3</b>	<b>108,015.5</b>	<b>25,698.8</b>	<b>80.8</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,364.4	17,266.0	2,098.5	89.2
Даатгалын үйлчилгээ	72,270.0	50,497.0	21,773.0	69.9





Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,810.0	31,072.2	1,737.8	94.7
Газрын төлбөр	9,269.9	9,180.3	89.6	99.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>146,342.4</b>	<b>145,950.2</b>	<b>392.2</b>	<b>99.7</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,977.2	4,977.2	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	141,365.2	140,973.0	392.2	99.7
<b>ТАТААС</b>	-	-	-	-
Татаас шилжүүлэг	-	-	-	-
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,581.2</b>	<b>46,194.9</b>	<b>3,386.3</b>	<b>93.2</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>49,581.2</b>	<b>46,194.9</b>	<b>3,386.3</b>	<b>93.2</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,581.2	26,296.9	3,284.3	88.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000.0	19,898.0	102.0	99.5
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>3,998,145.9</b>	<b>3,998,145.9</b>	-	<b>100.0</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-	-	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,998,145.9	3,998,145.9	-	100.0
<b>Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт</b>	-	-	-	-
Байгууллагын тоо	1	1	-	
Ажиллагсдын тоо	129	105	24	
Удирдах ажилтан	10	10	0	
Гүйцэтгэх ажилтан	89	73	16	
Үйлчилгээний ажилтан	30	22	8	



**5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>2018 он</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>САГ-2019/13/СТА-ТЭЗ</b>
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		<b>Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч</b>		<b>сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	Хэвлэл мэдээллийн 3 байгууллагад 2019 онд мэдээлэл, зар сурталчилгаа явуулах 7.1 сая төгрөгийг данс хаагдах өдөр шилжүүлж, авлагаар бүртгэсэн тул 2018 оны санхүүгийн тайланд авлагын данс өмнөх оны эцсийн үлдэгдлээс 6.2 сая төгрөгөөр өссөн байна.	6.2	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
2	Нийтийн эзэмшлийн бетондсон болон асфальтан 0.3 сая төгрөгийн талбай Чингэлтэй дүүргийн дансанд давхар бүртгэлтэй, 42.9 сая төгрөгийн дулааны ялтсан бойлер аргачлалд тусгагдаагүй тул дахин үнэлгээнд хамрагдаагүй байна.	0.3	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
3	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс балансад бүртгэлтэй 13 автомашинд нийт 10.1 сая төгрөгийн урсгал засвар хийхдээ комиссын гишүүдийн дүгнэлтийг тухай бүр гаргуулалгүй үйлчилгээ хийгдсэн байна.	10.1	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
4	2018 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нийт 261.0 сая төгрөгөөр батлагдаж Тамгын газрын даргын 2018 оны А/03, А/14А, А/15А дугаар тушаалаар байгууллагын төсвийн зарцуулалтын хоёрдугаар гарын үсэг зурж буй Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн даргыг Үнэлгээний хорооны даргаар томилж ажиллуулсан нь санхүүгийн хяналт алдагдах эрсдэл учирч болохоор байна.	-	Зөвлөмж өгсөн	Тамгын газрын дарга Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
5	Тамгын газрын даргын 2018 оны А/67 дугаар тушаалаар 14 албан хаагчид нийт 2.5 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо НДШ 0.3 сая төгрөгийг суутгалгүй илүү олгосон байна.	0.3	Төлбөрийн акт тогтоосон	Тамгын газрын дарга Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга	Ж.Наранпүрэв Н.Булгамаа



Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	Тайлант онд “Ард даатгал” ХХК-тай D181003109476 дугаар гэрээ байгуулж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийн амь нас, эрүүл мэндийг даатгуулахдаа томилогдоогүй нэг шүүгчийн даатгалын зардал 1.7 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байна.	1.7	Төлбөрийн акт тогтоосон	Тамгын газрын дарга Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга	Ж.Наранпүрэв Н.Булгамаа
<b>Дүн</b>		<b>18.6</b>			



# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2019 оны 04 дугаар сарын 23

№ 02/84

Улаанбаатар хот

САГ-2019/13/СТЭ-ТЭЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тамгын газрын даргын 2018 оны А/67 дугаар тушаалаар 14 албан хаагчид нийт 2,520,000.0 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл 277,200.0 төгрөгийг суутгалгүй илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Түлээ нүүрсний хөнгөлөлтөд хуулийн дагуу шимтгэл тооцоогүй нийт 277,200.0 /хоёр зуун далан долоон мянга хоёр зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Н.Булгамаа нарт хариуцуулав.

## АКТЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.НАРАНПҮРЭВ

САНХҮҮ, ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.БУЛГАМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2019\0423SAG1.Docx

070264





# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2019 оны 09 дугаар сарын 23

№ 02/85

Улаанбаатар хот

САТ-2019/13/СТА-783

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд “Ард даатгал” ХХК-тай D181003109476 дугаар гэрээ байгуулж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийн амь нас, эрүүл мэндийг даатгуулахдаа томилогдоогүй нэг шүүгчийн даатгалын зардал 1,671,333.0 төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.1 дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Даатгалын зардалд илүү шилжүүлсэн 1,671,333.0 /нэг сая зургаан зуун далан нэгэн мянга гурван зуун гучин гурван/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Н.Булгамаа нарт хариуцуулав.

### АКТЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.НАРАНПҮРЭВ

САНХҮҮ, ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСЭЙН ДАРГА

Н.БУЛГАМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тасансан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна” гэж заасны дагуу харуулагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2019\0423SAG2.Docx

070267



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.





## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.